

<https://doi.org/10.69561/mjac.v25i49.3832>

Article | Fasc.7

“Соёл”-ын тодорхойлолтын агуулгын шинжилгээ /1871-2019 он/

Батжаргалын Амарбаяр ✉ 

Соёл, урлагийн их сургуулийн Оюутны хөгжил, үйлчилгээний газар,
Улаанбаатар, Монгол Улс
✉ amaraa.culture@gmail.com

Жамъянгийн Долгорсүрэн 

Сити их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Соёлын ойлголт нь нарийн төвөгтэй, олон талт учраас тодорхойлох оролдлого нь эрдэмтдийн дунд маргаантай хэвээр байна. Энэхүү судалгаанд 1871-2019 оны хооронд дэвшүүлсэн 304 соёлын тодорхойлолтыг шинжилж, тэдгээрийг онолын үндэс, агуулга, үгийн давтамжаар ангилсан. Судалгааны үр дүнд функционализмын онол давамгайлж буйг тогтоосон бөгөөд үгсийн давтамжийн шинжилгээгээр “хүн”, “амьдралын хэв маяг”, “зан үйл” зэрэг үгс өндөр давтамжтайгаар илэрч, соёл хэмээх ойлголтын гол субъект нь хүн гэдгийг харуулсан. Мөн соёлын тодорхойлолтыг бүрдүүлж буй элементэд тулгуурлан соёлыг 12 янзаар тодорхойлсон. Судалгаа нь соёлын талаарх цогц мэдлэгийг хөгжүүлэх, нэгдсэн тодорхойлолт гаргах цаашдын судалгаанд суурь болох ач холбогдолтой.

Түлхүүр үгс: функционализм, хүний төвтэй хандлага, онолын ангилал, үгийн давтамж, системчилсэн бүтэц, зан үйл, амьдралын хэв маяг, уламжлал

A content analysis of the Cultural definitions (1871-2019)

Amarbayar Batjargal ✉ 

Department of the Students' Development and Service, Mongolian National
University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ amaraa.culture@gmail.com

Dolgorsuren Jamiyan 

Graduate School of Citi University, Ulaanbaatar, Mongolia

Abstract: the concept of culture is inherently complex and multifaceted, with attempts to define it remaining a subject of scholarly debate. This study analyzed and classified 304 cultural definitions proposed between 1871 and 2019, focusing on their theoretical foundations, content, and word frequency. The findings indicate that

functionalist theory predominates among these definitions. Word frequency analysis revealed a high recurrence of terms such as “person”, “lifestyle”, and “behavior”, underscoring the centrality of the individual in conceptualizing culture. Moreover, based on the definitional elements, culture was categorized into 12 distinct types. This research contributes to the development of a comprehensive understanding of culture and offers a foundation for future efforts to formulate a unified definition.

Keywords: *functionalism, human-centered approach, theoretical classification, word frequency analysis, systematic structure, behavior, lifestyle, tradition*

Оршил

Соёлын тухай ойлголт нь хүн төрөлхтөний түүхэнд хувьсан өөрчлөгдөж, хөгжсөөр ирсэн өргөн цар хүрээтэй ойлголтын нэг билээ. Юуг “соёл” хэмээн үзэж болох вэ? гэдэг нь өнөөдрийг хүртэл эрдэмтэн судлаачдын дунд маргаантай асуудал хэвээр байгаа нь энэ ойлголтын нарийн төвөгтэй байдал, олон талт чанарыг харуулж байна. Ялангуяа соёлыг тодорхойлоход хүн судлалын эрдэмтэд хүндтэй байр суурийг эзэлдэг. Тухайлбал, монгол эрдэмтэн судлаачдын бүтээсэн “Хорин нэгтийн тайлбар толь”-д “Эрдмээр хөхиүлэн хөгжүүлэхийг соёл хэмээхүй” (Хорин нэгтийн тайлбар толь 1717) гэсэн байдаг. Английн антропологич Эдуард Тайлор “Соёл бол нийгмийн гишүүн болох хүнд зуршмал байдаг мэдлэг, урлаг, ёс суртахуун, эрх, зан заншил болон бусад онцлогуудын цогц юм” (Tylor 1871) гэж тодорхойлж байсан ба түүнээс хойш соёлын талаарх хэдэн зуун тодорхойлолт гарсан гэдэг боловч яг хэд хүрээд байгаа нь тодорхойгүй байна. Энэ нь соёлыг олон янзын өнцгөөс, олон түвшинд тайлбарлах оролдлогууд хийгдсээр ирснийг илтгэж, соёлын утга агуулга, зорилго, ач холбогдлыг цогц утгаар нэгтгэн тодорхойлох амаргүй болохыг харуулж байна.

Зарим эх сурвалжийн мэдээг авч үзэхэд, оросын судлаачид Л.Е.Кертман соёлын талаар 400 гаруй тодорхойлолтыг тоолсон гэдэг (В.И.Полищук 1993) бол, мөн оросын судлаач К.М.Хоруженко өөрийн бичсэн “Соёл судлалын нэвтэрхий толь бичиг”-тээ соёлын тухай тодорхойлолт хагас мянгад хүрснийг тэмдэглэсэн байна (К.М.Хоруженко 1997). Америкийн хүн судлаач Альфред Л.Кробер, Клайд Клюкхон нар 1952 онд “Culture. A Critical Review of Concepts and Definitions” (1951) нэртэй бүтээлдээ 300 гаруй хүн судлалын судалгааны ажил үзэж, 1871-1951 оны хооронд гарсан соёл хэмээх ойлголтын 164 тодорхойлолтын утгыг долоо ангилан системчлэх оролдлого хийсэн нь энэ чиглэлийн судалгааны үндэс суурийг тавьсан гэж ойлгож болно. Америкийн эрдэмтэн Г.М.Робинсон, Хосе Каусадиа, Польшийн эрдэмтэн Роберт Бороч нар Альфред Л.Кробер, Клайд Клюкхон нарын дээрх бүтээлд задлан шинжлэл хийж, түүгээрээ хэд хэдэн эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлснээс өөрөөр энэ чиглэлийн судалгаа хараахан хийгдээгүй байна.

Бид Альфред Л.Кробер, Клайд Клюкхон нарын цуглуулсан 164 соёлын тодорхойлолтод үндэслэн 2021 оноос хойш нэмэлт судалгаа хийж, одоогийн байдлаар нийт 304 тодорхойлолтыг цуглуулаад байна. Эдгээр тодорхойлолтуудыг гаргасан эрдэмтдийг улс орон, мэргэжлээр нь ангилан, хүснэгтээр харуулсан болно. Судалгаанд хамрагдсан 191 эрдэмтний дэвшүүлсэн 304 тодорхойлолт нь тухайн

эрдэмтэн бүр өөрийн судалгааны чиглэл, сонирхож буй аспектээсээ хамааран соёлыг олон талаас тодорхойлж байсантай холбоотой юм.

Хүснэгт 1. Эрдэмтдийн улс орны харъяалал болон мэргэжил

№	Улс орноор	Эрдэмтдийн тоо	Мэргэжлээр	Эрдэмтдийн тоо
1	АНУ	128	Социологич	90
2	Монгол	11	Антропологич	44
3	Их Бритиан	11	Философич	16
4	Орос	9	Сэтгэл судлаач	15
5	Герман	7	Соёл судлаач	10
6	Энэтхэг	5	Эдийн засагч	4
7	Франц	4	Хэл шинжлэлч	4
8	Польш	3	Археологич	3
9	Бусад улс	13	Бусад мэргэжил	5
Нийт		191		191

Энэхүү өгүүллийн хүрээнд 1871-2019 оны хооронд олон улсын эрдэмтэн судлаачдын дэвшүүлсэн 304 соёлын тодорхойлолтыг судалж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт хийхийг зорьсон. Энэ зорилгын хүрээнд соёлын тодорхойлолтуудыг нарийвчлан судлахын тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Соёлын тодорхойлолтуудыг соёл судлалын онол, арга зүйн хүрээнд ангилан шинжлэх замаар ямар онол давамгайлж байгааг тодорхойлох
2. Тодорхойлолтуудад ашигласан үгсийн давтамжийг судалж, агуулгын үндсэн утгыг гарган дүгнэлт хийх
3. Тодорхойлолтуудын гол утга санааг илэрхийлж буй нэр үгсийн давтамжид үндэслэн соёлын үндсэн элементүүдийг тодорхойлох

Дээрх зорилгыг хэрэгжүүлснээр соёл судлалын судлагдахуун, түүний олон талт ойлголтуудын талаар илүү гүнзгий, мэдлэг олж авах чухал ач холбогдолтой. Энэ судалгаа нь өмнөх судалгаатай харьцуулахад илүү өргөн цаг хугацаа, цар хүрээг хамарч байна. Түүнчлэн, өмнөх судалгаанд тухайн тодорхойлолтуудыг тус бүрээр нь авч үзэх хандлага зонхилж байсан бол, энэхүү судалгаа нь тэдгээрийг харьцуулан шинжилж буйгаараа онцлогтой. Энэхүү судалгаа нь цаашид соёлын судлагдахуун, ойлголтын олон талт байдлыг системчилж, улмаар соёлыг шинээр тодорхойлох, нэгдсэн загвар гаргах судалгааны үндэс суурийг тавихад чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

Судалгааны арга зүй

Энэхүү өгүүллийн хүрээнд дэвшүүлсэн гурван зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах онол, арга зүйг ашиглан судалгаа явуулна.

Нийт 304 соёлын тодорхойлолтын бүтэц, үүрэг, үйл ажиллагаа, утга агуулга, бодит материаллаг хүчин зүйлсийг соёл судлалын онолуудад тулгуурлаж, онолын задлан шинжлэл хийх болно. Мөн тодорхойлолтуудад ашигласан үгсийн давтамжийг агуулгын шинжилгээ хийдэг “Voyant Tools” программ ашиглан судалж, хамгийн өндөр давтамжтай таван үгийг “үгийн үүл” хэлбэрээр тодорхойлон


дүгнэлт гаргана.

Соёлын тодорхойлолтыг нэгдмэл систем гэж үзэн, түүний бүрдэл хэсгүүдийг илэрхийлэх нэр үгсийг тодорхойлж, давтамжаар нь эрэмбэлэх замаар соёлын үндсэн элементүүдийг тогтооно.

Судалгааны үр дүн

Энэхүү өгүүллийн зорилгын хүрээнд гурван үндсэн зорилт тавигдсан бөгөөд эхний зорилт нь соёлын тодорхойлолтуудыг соёл судлалын онол, арга зүйн хүрээнд ангилан шинжлэх замаар ямар онол давамгайлж байгааг тодорхойлох юм. Үүнтэй холбогдуулан соёл судлалын онол, арга зүйн хүрээнд соёлын тодорхойлолтуудыг ангилан шинжилсэн.

Тухайлбал, функционализм, хувьслын онол, соёлын дамжуулалт, бэлгэдлийн онол, соёлын материализм, бүтцийн онол, идеалист онол, соёлын бүтэц-үйл ажиллагааны онол, соёлын релятивизм, соёлын дасан зохицох онол зэрэг гол онолуудад тулгуурлан соёлын тодорхойлолтууд бичсэн байна гэж үзсэн. Үүнээс гадна соёлын сэтгэл судлал, соёлын экологи, соёлын постмодернист онол, соёлын түгээмэл шинжийн онол, соёлын нийгмийн бүтцийн онол, трансцендентализм зэрэг онолууд 5-аас бага давтамжтай байна.



Зураг 1. Соёлын тодорхойлолтын онолын давтамж

13 удаа, соёлын бүтэц-үйл ажиллагааны онол 12 удаа, соёлын релятивизм 8 удаа, соёлын дасан зохицох онол 8 удаа, бусад онол нийт 16 удаа илэрчээ. Эдгээр онолууд нь соёлын судалгааны хүрээ, чиглэлээс хамааран өргөн хэрэглэгддэг бөгөөд түүнээс функционализм нь хамгийн өргөн хэрэглэгдэж буй онол болох нь тодорхой байна.

Нэмж дурдахад, нийт 304 соёлын тодорхойлолтыг 191 эрдэмтэн судлаачид гаргасан бөгөөд үүнээс 90 орчим нь хүмүүнлэг, нийгмийн шинжлэх ухааны салбарт судалгаа хийсэн эрдэмтэд байгаагаас үзэхэд, соёлыг функционализм онолын үүднээс судлах хандлага давамгайлж байгааг харуулж байх талтай байна.

Хүснэгт 2. Соёлын тодорхойлолтын дэд систем

№	Дэд систем	Элементийн тоо
1	Соёлын бүтэц, тогтолцоо, систем	8
2	Хүмүүс, бүлэг, хүний оршихуй	2
3	Нийгмийн харилцан үйлчлэл, хандлага, амьдралын хэв маяг	11
4	Өв уламжлал, ардын уламжлал	4
5	Этик, ёс зүй, зан үйл, зан араншин	6
6	Материаллаг ба материаллаг бус хүчин зүйлс	3
7	Үйл явц, үйл ажиллагаа	5
8	Урлаг, мэдлэг, чадвар, туршлага	3
9	Итгэл үнэмшил, сүсэг бишрэл, үнэт зүйлс	3
10	Сэтгэл зүй, ухамсар, мэдлэг	2
11	Бэлгэдэл, үзэл бодол, эрч хүч	3
12	Боловсрол, ур чадвар, мэдрэмж	5
	Нийт	55

Дээрх соёлын тодорхойлолтын 12 дэд системийг 55 элемент бүрдүүлж байгаа бөгөөд эдгээр 55 элементийн хамгийн давтамж өндөртэй элементийг зураг 3-аар харуулав. Зураг 3-аас харахад, соёлын тодорхойлолтуудын гол цөм нь хүн, түүний амьдралын хэв маяг, зан үйл, уламжлал, систем, нийгэмтэй нягт холбоотой болохыг илтгэнэ. “Хүн” хамгийн өндөр давтамжтай (138 удаа) дурдагдсан нь соёлын мөн чанарыг хүн төвтэй гэж үздэгтэй уялдана. Энэ нь соёл бол хүний бүтээл бөгөөд хүний хэрэгцээ, оршихуй, оролцоо, үйлдлүүдээр тодорхойлогддогийг харуулж байна.

“Амьдралын хэв маяг” 135 удаа давтагдаж байгаа нь соёл нь хүний өдөр тутмын үйл ажиллагаа, зан чанар, харилцаа, үнэт зүйлсийн тусгал гэдгийг баталж байгаа юм. Альфред Л.Кробер, Клайд Клюкхон нарын соёлын талаар баримтлах хандлагын үүднээс авч үзвэл, “амьдралын хэв маяг” гэдэг нь соёл өөрийн илэрхийлэгдэж буй орчиндоо дасан зохицох арга зам бөгөөд цаг хугацаанаас хамааран хувьсан өөрчлөгддөг шинжтэй гэж үзэж болно.

“Өв уламжлал” (105 удаа) нь соёлын чухал хэсэг болохыг харуулна. “Өв уламжлал бол түүхэн явцад бий болсон үнэт зүйлс, мэдлэг, туршлага, зан үйл, итгэл үнэмшлийн дамжуулалт юм. Энэ нь соёлын үргэлжлэх үйл явц бөгөөд хувь хүнээс нийгэм рүү, үеэс үед дамждаг чухал элементүүдийг агуулдаг” (Tylor 1871) гэж хэлж болно.


Соёлын тодорхойлолтуудад “Систем” (74 удаа) болон “Зан үйл” (74 удаа) ижил түвшинд дурдагдсан нь соёлын бүтэцлэгдсэн шинж, зохион байгуулалттай харилцаа, үйл явцыг илэрхийлнэ. Герберт Спенсер (1876) “Соёл нь тогтвортой хэм хэмжээ, дүрэм, харилцан үйлчлэлийн системийг агуулдаг бол зан үйл нь эдгээрийг биелүүлдэг практик хэрэгжилт юм” гэсэн санааг анх дэвшүүлсэн байдаг.

“Материаллаг зүйл” (67 удаа) болон “Нийгэм” (59 удаа) нь соёлын салшгүй

хэсэг гэдгийг харуулж байна. “Материаллаг зүйлс нь соёлын бодит, харагдахуйц илэрхийлэл болох ба үүнд урлаг, эд зүйл, барилга, хувцас зэрэг багтдаг. Харин нийгэм бол соёлын суурь орчин бөгөөд хүмүүсийн харилцаа, хамтын ажиллагаа, зохион байгуулалт, хамтын итгэл үнэмшлээр тодорхойлдог” (Мейе 1903).

“Үйл ажиллагаа” (44 удаа) нь соёлын тодорхойлолтод чухал байр суурь эзэлдэг гэж үзэж болохоор байна. Соёл бол зөвхөн үзэл баримтлал төдий зүйл биш, харин хувь хүмүүс болон нийгмийн бүлгүүдийн өдөр тутамд хэрэгждэг амьд үйл явц юм.

Дүгнэж хэлэхэд, соёл нь хүн төвтэй, олон талт, материаллаг болон материаллаг бус шинж чанаруудыг хослуулсан, нийгэм, уламжлал, зан үйлтэй салшгүй холбоотой болохыг тодорхой харуулж байна (Зураг 3). Энэ нь соёлын үндсэн мөн чанарыг илтгэх чухал ойлголт юм.



Зураг 3. Соёлын тодорхойлолтын элементийн давтамж

Хэлэлцүүлэг

Альфред Л.Кробер, Клайд Клюкхон нар 1871-1951 оны хооронд гаргасан соёлын 164 тодорхойлолтыг зөвхөн утгын хүрээнд долоо ангилан системчлэх оролдлого хийсэн ба бидний энэхүү судалгаа нь нэгдүгээрт, соёлын тодорхойлолтын тоо болон цаг хугацаа хамрах хүрээны хувьд ялгаатай, хоёрдугаарт, тодорхойлолтыг соёл судлалын нийтлэг онолын хүрээнд гурван түвшинд задлан шинжилснээрээ онцлог юм. Мөн соёлыг судлах үндсэн 12 чиглэлийн судалгааны үндэс суурийг тавьсан гэж ойлгож болно.

Өөрөөр хэлбэл, судалгаанд 1871-2019 оны хооронд олон улсын эрдэмтэн судлаачдын боловсруулсан 304 тодорхойлолтыг багтаан шинжилсэн нь цаг хугацааны өргөн цар хүрээг хамарсан судалгаа болсон.

Нэгдүгээрт, судалгааны үр дүнд соёлын тодорхойлолтуудыг үндэслэсэн онолуудыг ангилан шинжилсэн нь функционализм онол хамгийн их (91 удаа) давтамжтайгаар хэрэглэгдсэнийг харуулсан нь соёлыг практик үүрэг, үйл ажиллагаатай холбон тайлбарлах чиглэл давамгайлж буйг илтгэнэ. Бусад онол, тухайлбал, хувьслын онол (39 удаа), бэлгэдлийн онол (33 удаа) нь харьцангуй бага давтамжтай боловч тухайн чиглэлээр соёлыг тайлбарлах чухал үүрэг гүйцэтгэсээр байна.

Хоёрдугаарт, тодорхойлолтуудад ашигласан үгсийн давтамжийн шинжилгээ нь соёлын үндсэн утга агуулгыг тодорхойлоход тусалсан. Хамгийн өндөр давтамжтай үгс болох “соёл”, “нийгмийн”, “хүний”, “зан үйл”, “үйл ажиллагаа” нь соёлын төв болох хүн, түүний үйл ажиллагаа, зан үйл, нийгмийн орчныг онцолсон болохыг харуулж байна. Энэ нь соёл бол зөвхөн материаллаг бус үнэт зүйлсийн цогц биш, харин хүний өдөр тутмын үйл явдал, харилцааны практик илэрхийлэл болохыг харуулж байна.

Гуравдугаарт, судалгаа нь соёлыг системтэй тайлбарлах оролдлогын нэг хэсэг болж, тодорхойлолтуудын 12 дэд системийг тогтоосон нь соёлын олон талт шинжийг системчилж харах боломжийг бүрдүүлсэн. Тухайлбал, “хүн”, “амьдралын хэв маяг”, “өв уламжлал”, “систем” зэрэг элементүүдийн давтамжийн харьцаа нь соёлын мөн чанарыг илтгэж байна.

Дүгнэлт

Энэхүү өгүүллийн хүрээнд 1871-2019 оны хооронд олон улсын эрдэмтэн судлаачдын дэвшүүлсэн 304 соёлын тодорхойлолтыг судалж, шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт хийхийг зорьж, улмаар энэ хүрээнд соёлын тодорхойлолтуудыг соёл судлалын онол, арга зүйн хүрээнд ангилан шинжлэх замаар ямар онол давамгайлж байгааг тодорхойлох, тодорхойлолтуудад ашигласан үгсийн давтамжийг судалж, агуулгын үндсэн утгыг гарган дүгнэлт хийх, тодорхойлолтуудын гол утга санааг илэрхийлж буй нэр үгсийн давтамжид үндэслэн соёлын үндсэн элементүүдийг тодорхойлох зэрэг оролдлого хийв.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлснээр дараах хэд хэдэн дүгнэлтийг хийж байна. Нэгдүгээрт, соёлын тодорхойлолтын олон талт байдал: Соёлын ойлголтыг тодорхойлох оролдлого нь эрдэмтдийн дунд маргаантай хэвээр байгаа нь соёлын нарийн төвөгтэй, олон талт шинжийг харуулж байна. Судалгаанд 304 тодорхойлолтыг хамруулсан нь соёлын талаарх үзэл санаа, онолын хандлагууд улам бүр өргөжиж, илүү тодорхой болж байгааг илтгэнэ.

Хоёрдугаарт, функционализм онолын давамгайл байдал: Тодорхойлолтуудын дийлэнх нь функционализм онолд тулгуурласан нь соёлын үүрэг, практик хэрэглээ, нийгмийн зохион байгуулалтын ач холбогдлыг онцолсныг харуулж байна. Энэ нь соёлыг нийгмийн орчинд хүн төрөлхтний хэрэгцээ, үйл ажиллагаанаас үүдэлтэй цогц систем гэж үзэх суурь ойлголтыг бататгалаа.

Гуравдугаарт, хүн төвтэй соёлын тайлбар: Судалгаанд хамгийн өндөр давтамжтайгаар дурдагдсан үгс нь “хүн”, “амьдралын хэв маяг”, “зан үйл” зэрэг ойлголтууд байлаа. Энэ нь соёлын нэг бүхэллэг систем гэж үзвэл, түүний үндсэн

субъект нь хүн бөгөөд соёл нь хүний зан үйл, харилцаа, итгэл үнэмшил, өдөр тутмын амьдралын бодит илэрхийлэл болохыг баталж байна.

Дөрөвдүгээрт, соёлын системчилсэн бүтэц: Судалгаагаар 12 дэд системийг илрүүлж, соёлын бүрэлдэхүүн хэсгүүдийг тодорхойлсон нь соёлыг илүү иж бүрэн, системтэйгээр ойлгоход дөхөм болсон.

Тавдугаарт, үгсийн давтамжийн шинжилгээний ач холбогдол: “Voyant Tools” программыг ашигласан шинжилгээний үр дүнд соёлын үндсэн элементүүдийг үгийн үүл хэлбэрээр тодорхойлсон нь тодорхойлолтуудын гүн агуулгыг гаргахад тусаллаа. Энэ арга зүй нь судалгааны ил тод байдал, объектив байдлыг хангах шинэлэг арга болсон.

Зургаадугаарт, энэ судалгаа нь соёлын олон янзын тодорхойлолтуудыг нэгтгэн системчилсэн, илүү өргөн цаг хугацаа, цар хүрээг хамарснаараа онцлог бөгөөд, улмаар соёлын олон талт ойлголтыг нэгтгэн дүгнэх, шинэлэг загвар боловсруулахад чухал суурь болж, цаашдын судалгааны өргөн боломжийг нээж өгч байна.

Ашигласан материалын жагсаалт

Boroch, Robert. 2016. “A Formal Concept of Culture in the Classification of Alfred L.Kroeber and Clyde Kluckhohn.” *Analecta XXV*, Vol. 2: 61–101. <https://www.researchgate.net/publication/331166147> 41.

Geertz, Clifford. 1973. *The Interpretation of Cultures*. New-York: HYPERLINK “https://en.wikipedia.org/wiki/Basic_Books” \o “Basic Books” Basic Books .

Kluckhohn, Alfred L. Kroeber and Clyde. 1951. *Culture. A Critical Review of Concepts and Definitions*. Cambridge: Harvard University Printing Office.

Causadias, Jose. 2020. “What is culture? Systems of people, places, and practice.” *Applied Development Science* Vol. 24, No. 4: 310-322.

Fand Lu, Robinson G. M. 1995. “A general review of culture.” *Journal of Dezhou University* (2): 65-69.

Tylor, Edward. 1871. *Primitive Culture*. New York: J.P.Putnam’s Sons.

Полищук В.И. 1993. *Мировая и отечественная культура*. Екатеринбург.

Хоруженко К.М. 1997. *Культурология энциклопедический словарь*. Феникс.

1717. *Хорин нэгтийн тайлбар толь*.